



МОНГОЛ УЛСЫН 2 ДАХЬ ШАТНЫ ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН 2019

2019 ОНЫ 10 ДУГААР САР



DISCLAIMER: This document is an unofficial translation of the APG 2nd Mutual Evaluation Follow-Up Report of Mongolia (2019), which is provided for information purposes. The official version of the document is the English text published on the APG website (www.apgml.org). The APG bears no responsibility for any inaccuracies in this unofficial translation. In the case of any discrepancy or conflict between this translation and the original English version, the official version of this document published on APG website takes precedence.

АНХААРУУЛГА: Энэ баримт бичиг нь Монгол Улсын 2 дахь шатны дахин үнэлгээний тайлан (2019)-ийн албан бус мэдээллийн чанартай орчуулга болно. Албан ёсны англи хэл дээрх хувилбар нь АНДББ-ийн веб хуудсанд нийтэлсэн болно (www.apgml.org). АНДББ нь энэ тайлангийн албан бус орчуулгын талаар ямар нэгэн хариуцлага хүлээхгүй. Албан ёсны англи хэл дээрх тайлан болон орчуулгын хооронд ойлголтын зөрүү, зөрчил үүсвэл англи хэл дээрх АНДББ веб хуудсанд нийтэлсэн хувилбарыг баримтална.



Ази, Номхон далайн бүсийн мөнгө угаахтай тэмцэх байгууллага (АНДББ) нь Ази, Номхон далайн бүсийн улс орнууд, олон улсын болон бүс нутгийн бус хэд хэдэн ажиглагч байгууллагыг эгнээндээ нэгтгэсэн 41 гишүүнтэй засгийн газар хоорондын байгууллага билээ.

АНДББ нь 2012 онд гаргасан АНДББ-ын Үндсэн дүрмийн 1 дүгээр зүйлд зааснаар улс төрөөс ангид, техникийн шинжтэй, гишүүд нь Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-аас гаргасан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхийн эсрэг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартыг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилготой байгууллага юм.

Энэхүү баримт бичиг болон энэхүү баримт бичигт дурдсан аливаа хэллэг болон газрын зураг нь аливаа нутаг дэвсгэр, олон улсын хил хязгаар, хот, бүсийн нэрний статус, бүрэн эрхт байдлыг хөндөөгүй болно.

АНДББ-ын Үндсэн дүрмийн дагуу Ази, Номхон далайн бүст харьяалагдах аль ч улс, орон АНДББ-г гишүүнээр элсэх боломжтой.

АНДББ-ын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг www.apgml.org веб хуудаснаас авна уу.

© АНДББ 2019 оны 10 дугаар сар

Энэхүү тайланг зөвхөн бичгээр авсан зөвшөөрлийн дагуу хэвлэх буюу орчуулах боломжтой. Энэхүү тайланг бүхлээр эсхүл хэсэгчлэн хэвлэх зөвшөөрлийг авахын тулд дараах хаягаар хүсэлт гаргана уу:

APG Secretariat
Locked Bag A3000
Sydney South
New South Wales 1232
AUSTRALIA
Tel: +61 2 5126 9110

Э-мэйл: mail@apgml.org
Веб: www.apgml.org

Хавтасны зураг: Монгол Улсын Засгийн газраас авав.



**МОНГОЛ УЛСЫН: ӨРГӨТГӨСӨН ЭРЧИМТЭЙ 2 ДАХЬ ШАТНЫ
ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН 2019**

I. УДИРТГАЛ

1. Монгол Улсын харилцан үнэлгээний тайлан (ХҮТ) нь 2017 оны 7 дугаар сард батлагдсан. Тус ХҮТ-д тодорхойлсон техникийн хэрэгжилтийн дутагдлыг арилгах үйл ажиллагааны хүрээнд гарсан ахиц, дэвшилд гарсан дүн шинжилгээг энэхүү Дахин үнэлгээний тайлан (ДҮТ)-нд тусгав. Техникийн хэрэгжилтийн дахин үнэлгээг хангалттай ахиц дэвшил гарсан тохиолдолд өгсөн болно. Энэхүү тайлан нь ХҮТ батлагдсанаас хойш өөрчлөгдсөн ФАТФ-ын зөвлөмжтэй холбоотой шинэ шаардлага (Зөвлөмж 2, 5, 7, 8, 18, 21)-ыг хэрэгжүүлэхэд гарсан ахиц дэвшилд мөн дүн шинжилгээ хийв.

2. Энэ тайлан нь Монгол Улсын Үр дүнтэй байдлаа нэмэгдүүлэх талаар хийсэн ажлыг дүгнээгүй бөгөөд Үр дүнтэй байдлыг дараагийн дахин үнэлгээний тайлангаар дүгнэх бөгөөд Шууд хэрэгжилтийн үнэлгээг тухайн үед дахин авч үзэх болно.

3. Монгол Улсын хүсэлтийн дагуу техникийн хэрэгжилтийн дахин үнэлгээ, энэхүү тайланг бэлтгэхэд дараах мэргэжилтнүүд оролцов:

- Ноён Айбек Турдукулов, ЕАГ-ын Нарийн бичгийн дарга нарын газар
- Ноён Эндрю Холмс, Шинэ Зеландын Дотоод хэргийн яам
- Ноён Гэвин Раптер, Австралийн Гүйлгээний тайлан ба шинжилгээний төв
- Ноён Хосе Карапина, Макаогийн Санхүүгийн тагнуулын газар
- Ноён Сохаил Жан, Пакистаны Төрийн банк
- Ноён Захир Ахмед, Пакистаны Цагдаагийн газар
- Ноён Дэвид Бекер, АНДББ-ийн нарийн бичгийн дарга нарын газар
- Ноён Шеннон Рутерфорд, АНДББ Нарийн бичгийн дарга нарын газар
- Хатагтай Лорен Хирш, АНДББ-ийн Нарийн бичгийн дарга нарын газар
- Ноён Гимо Лаксамана, АНДББ Нарийн бичгийн дарга нарын газар
- Хатагтай Женни Фельтам, АНДББ Нарийн бичгийн дарга нарын газар

4. Энэхүү тайлангийн III хэсэгт техникийн хэрэгжилтийг сайжруулахад гарсан ахиц дэвшлийг нэгтгэн харуулав. Дөрөвдүгээр хэсэгт дүгнэлт, Монгол улсын техникийн хэрэгжилтийн үнэлгээг харуулсан хүснэгтийг оруулсан болно.

II. ХАРИЛЦАН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН ҮР ДҮН

5. Монгол Улсын ХҮТ-ийн гарсан үнэлгээ (2017):

Техникийн Хэрэгжилтийн үнэлгээ (ББ – бүрэн биелүүлсэн, ИБ – ихэнхийг биелүүлсэн, ХБ – хэсэгчлэн биелүүлсэн, БГ – биелүүлээгүй)

ЗӨВ. 1	ЗӨВ. 2	ЗӨВ. 3	ЗӨВ. 4	ЗӨВ. 5	ЗӨВ. 6	ЗӨВ. 7	ЗӨВ. 8	ЗӨВ. 9	ЗӨВ. 10
ХБ	ХБ	ИБ	ИБ	ИБ	ХБ	НС	БГ	ХБ	ИБ
ЗӨВ. 11	ЗӨВ. 12	ЗӨВ. 13	ЗӨВ. 14	ЗӨВ. 15	ЗӨВ. 16	ЗӨВ. 17	ЗӨВ. 18	ЗӨВ. 19	ЗӨВ. 20
ББ	ИБ	ИБ	ХБ	ИБ	ИБ	БГ	ИБ	ХБ	ИБ
ЗӨВ. 21	ЗӨВ. 22	ЗӨВ. 23	ЗӨВ. 24	ЗӨВ. 25	ЗӨВ. 26	ЗӨВ. 27	ЗӨВ. 28	ЗӨВ. 29	ЗӨВ. 30
ХБ	БГ	БГ	ХБ	ХБ	ХБ	ИБ	БГ	ХБ	ББ
ЗӨВ. 31	ЗӨВ. 32	ЗӨВ. 33	ЗӨВ. 34	ЗӨВ. 35	ЗӨВ. 36	ЗӨВ. 37	ЗӨВ. 38	ЗӨВ. 39	ЗӨВ. 40
ББ	ХБ	ХБ	ХБ	ХБ	ББ	ББ	ИБ	ИБ	ИБ

Үр дүнтэй байдлын үнэлгээ (Өндөр, Үлэмж, Дунд зэрэг, Доогуур)

ШХ1	ШХ2	ШХ 3	ШХ 4	ШХ 5	ШХ 6	ШХ 7	ШХ 8	ШХ 9	ШХ 10	ШХ 11
Доогуур	Дунд зэрэг	Доогуур	Доогуур	Доогуур	Доогуур	Доогуур	Дунд зэрэг	Доогуур	Доогуур	Доогуур

6. Эдгээр үр дүнг харгалзан Монгол Улсыг өргөтгөсөн эрчимтэй хяналтад (enhanced expedited follow-up)¹ оруулав.
7. Монгол Улс 2018 онд дахин үнэлгээний тайланд үнэлгээгээ ахиулах хүсэлт гаргаагүй байна.

III. ТЕХНИКИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЗӨВЛӨМЖИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

8. Энэ хэсэгт Монгол Улсын техникийн хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр гаргасан ахиц дэвшлийг дараах байдлаар тоймлон дүгнэсэн болно:

а) ХҮТ-д тодорхойлсон техникийн хэрэгжилтийн дутагдлыг арилгах,

б) ХҮТ батлагдсанаас хойш өөрчлөгдсөн ФАТФ-ын зөвлөмжийн шинэ шаардлагуудыг хэрэгжүүлэх.

3.1. ХҮТ-д тодорхойлсон техникийн хэрэгжилтийн дутагдлыг арилгахад гарсан ахиц дэвшил.

9. Монгол Улс дараах зөвлөмжүүдийн үнэлгээг ахиулах хүсэлт гаргасан: 7, 17, 22, 23, 28 (БГ үнэлгээтэй байсан); 1, 2, 6, 8, 14, 19, 21, 24, 25, 26, 29, 32, 33, 34, 35 (ХБ үнэлгээтэй байсан).

10. Мөнгө угаахтай тэмцэх Ази, Номхон далайн бүсийн байгууллага (АНДББ) нь Монгол Улсын Зөвлөмж 1, 2, 6, 7, 8, 14, 17, 19, 21, 22, 23, 24, 25, 26, 28, 29, 32, 33, 34, 35-ын техникийн хэрэгжилтийг сайжруулахад хэрэгжүүлсэн алхмуудыг сайшааж байна. Энэхүү ахиц дэвшлийн үр дүнд Монгол Улс Зөвлөмж 2, 6, 7, 17, 19, 21, 22, 23, 24, 25, 26, 28, 29, 32, 33, 34-ын үнэлгээг ахиулсан. Гэсэн хэдий ч Зөвлөмж 1, 8, 14, 35-ын үнэлгээг ахиулахад хангалттай ахиц дэвшил гаргаагүй байна.

Зөвлөмж 1 (Хэсэгчлэн биелүүлсэн (ХБ) үнэлгээтэй байсан)

11. Монгол улс ХҮТ-д Зөвлөмж 1 дээр ХБ үнэлгээ авсан. Монгол Улс нь 2016 онд анхны Үндэсний эрсдэлийн үнэлгээ (ҮЭҮ) гүйцэтгэсэн хэдий ч хязгаарлагдмал дүн шинжилгээ хийх замаар эрсдэлийг тодорхойлоход анхаарлаа хандуулсан. 2017 оны ХҮТ-нд салбарын эрсдэлийн үнэлгээ хийгдээгүй бөгөөд үл хөдлөх хөрөнгө, нягтлан бодогч, даатгал, үнэт металлын худалдаа эрхлэгчид, үнэт цаас, даатгал, мөнгөн гуйвуулга, хуулийн этгээд, олон нийтийн болон гадаадын ААН, Ашгийн бус байгууллага (АББ)-ын салбарт мөнгө угаах эрсдэлийг тодорхойлоогүй гэсэн дүгнэлт гарсан. Терроризмыг санхүүжүүлэх (ТС)-ийн хувьд ҮЭҮ нь Монгол Улсын ТС эрсдэл, ТС-д өртөх магадлалд маш хязгаарлагдмал тодорхойлолт, дүн шинжилгээ хийсэн байсан. Монгол Улс нь нөөц хуваарилах, ФАТФ-ын зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр эрсдэл суурилсан аргачлал хэрэгжүүлээгүй байсан. Нэмж дурдахад, зөвхөн үл хөдлөх хөрөнгийн зуучлагч, нотариатчдыг Мэдээлэх үүрэгтэй этгээд (МҮЭ)-ийн жагсаалтад оруулан, СБМҮҮ-ийг дутуу хамарсан байсан.

12. 2017 оны ХҮТ-с хойш Монгол Улс нь ББСБ зэрэг олон салбарын эрсдэлийн үнэлгээг хийсэн байна. Үл хөдлөх хөрөнгийн салбарт ТС эрсдэл байна гэж тодорхойлогдсон боловч дунд зэргийн ТС эрсдэл нь Монгол Улсын нөхцөлд ямар утгатайг бүрэн ойлгоход хүндрэлтэй.

13. Банкны салбарын эрсдэлийн үнэлгээг шинэчилсэн боловч аргачлал, үр дүнг нь ойлгоход бэрхшээлтэй байсан. Нэмж дурдахад, үнэт цаасны болон даатгалын салбарыг 2017 оны

¹ ХҮТ-ийн үр дүнгээс хамаарч гурван төрлийн хяналтад оруулна: жирийн, эрчимтэй хяналт болон өргөтгөсөн эрчимтэй хяналт. АНБДД-ийн Харилцан үнэлгээний зааврыг харна уу.

ХҮТ-д эрсдэл багатай гэж үзсэн хирнээ эдгээр салбарын эрсдэлийн үнэлгээг чухалчилсан үндэслэл нь тодорхойгүй байна. ТС эрсдэлийн үнэлгээнд төрийн бус байгууллага (ТББ)-уудад тулгарч буй ТС эрсдэлийн талаар төдийлөн дурдаагүй байсан бөгөөд яагаад Монгол Улс нь ТББ болон түүнтэй холбоотой эрсдэлийн талаар илүү дэлгэрэнгүй ойлголтыг боловсруулаагүй нь тодорхойгүй байна (ЗӨВ.8-д дурдсан дутагдлыг хүлээн зөвшөөрөх явцад). Монгол Улс хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хамаарах хэд хэдэн салбарын эрсдэлийн үнэлгээг хийсэн боловч хуулийн этгээдийн төрлөөс хамаарах эрсдэлийг үнэлээгүй байна. Нягтлан бодогч, үнэт металл, чулууны худалдаа эрхлэгч (ҮМЧХЭ), хуулийн этгээдийн хувьд эрсдэлийн үнэлгээ хийхээр төлөвлөж байгаа боловч хараахан хийж эхлээгүй байна.

14. Монголын эрх бүхий байгууллагууд МУТС эрсдэлийн талаарх ойлголт, сүүлийн хоёр жилийн хугацаанд хэрэгжүүлсэн нэмэлт эрсдэлийн үнэлгээнд үндэслэн тодорхой хэмжээнд Стратегийн төлөвлөгөө боловсруулах замаар засгийн газрын бүхий л салбаруудад нөөцийг хуваарилах стратегид төвлөрсөн арга барилыг хэрэгжүүлж эхэлсэн.

15. Зөвлөмж 22, 23-ын хүрээнд тулгамдаад байсан хамрах хүрээний асуудлыг ерөнхийд нь шийдвэрлэсэн бөгөөд одоогоор МҮЭ-ийн жагсаалтад зөвхөн Траст, компанийн үйлчилгээ үзүүлэгч (ТКҮҮ)-чид ороогүй байна. Эрчимжүүлсэн эсвэл хялбаршуулсан арга хэмжээ авах нь эрсдэл дээр үндэслэсэн эсэх нь тодорхойгүй байна. Түүнчлэн, олон нийтийн эсвэл орон нутгийн засаг захиргааны байгууллагууд нь засгийн газрын эрсдэл багатай хэсгийн нэг хэдий ч хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компаниуд яагаад эрсдэл багатай гэж тооцогдож байгаа болон энэ нь аливаа эрсдэлийн үнэлгээнд үндэслэсэн эсэх нь тодорхойгүй байна.

16. Нягтлан бодогч, хуульч, нотариатчидад хязгаарлагдмал хяналт шалгалт хийж, хамарч ажилласан явдал нь хяналт шалгалтын ажилтнууд бүх МҮЭ ЗӨВ.1-ийн шаардлагаа бүрэн биелүүлэхэд хяналт тавихгүй байгааг харуулж байна. Урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журамд бодлого, хяналт, журмыг дээд удирдлага батлах шаардлагатай гэж заагаагүй болно. Монгол Улс одоогоор МҮЭ-д хялбаршуулсан арга хэмжээ авах зөвшөөрөл олгосон хэдий ч эдгээр заалтууд нь эрсдэлд суурилагүй байна.

17. Монгол Улс 2017 онд ЗӨВ.1-ийн хүрээнд илэрсэн дутагдлыг арилгах чиглэлээр олон арга хэмжээ авсан байна. Үл хөдлөх хөрөнгө, үнэт цаас, даатгал болон ТС эрсдэлийн үнэлгээг эерэг гэх тодорхойлсон ч ямар үндэслэлээр ТББ-ын салбар болон үүнтэй холбоотой эрсдэлийг илүү нарийвчилж судлаагүй нь тодорхойгүй байна. Монгол Улс тодорхой хэмжээнд эрсдэл дээр суурилсан нөөцийн хуваарилалтыг удирдан чиглүүлэх, арга хэмжээ боловсруулах, хэрэгжүүлэх шийдвэр гаргасан байна. Урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам (УСҮАЖ), МУТСТ тухай хуулинд өндөр эрсдэлтэй бүс нутагт эрчимжүүлсэн ХТМ-ийг хэрэгжүүлэх талаар тусгаж өгсөн бөгөөд үүнд зөвхөн ТКҮҮ-ийг орхигдуулсан явдал нь жижиг хэмжээний зөрчил юм. Одоогийн байдлаар УСҮАЖ-нд хялбаршуулсан ХТМ арга хэмжээний талаар тусгаж өгсөн боловч эдгээр арга хэмжээ нь эрсдэлд суурилагүй тул стандартад нийцэхгүй байна. Мөн МУТСТ хуульд тодорхой нөхцөлд хялбаршуулсан ХТМ арга хэмжээ хэрэгжүүлж болно гэж заасан ч тэдгээр нөхцөлийг эрсдэл багатай нөхцөл гэж үнэлсэн нотлох баримт байхгүй байна. Нягтлан бодогч, хуульч, нотариатчдын хувьд хязгаарлагдмал хяналт хийж, хамарч ажилласан нь хяналт шалгалтын байгууллагууд ЗӨВ.1-ийн шаардлагыг бүрэн биелүүлэхэд хяналт тавихгүй байгааг харуулж байна.

18. **Монгол Улсын ЗӨВ.1-ийн үнэлгээг Хэсэгчлэн биелүүлсэн (ХБ) хэвээр үлдээв.**

Зөвлөмж 2 (Хэсэгчлэн биелүүлсэн (ХБ) үнэлгээтэй байсан)

19. Монгол Улс ХҮТ-д ЗӨВ.2 дээр ХБ үнэлгээ авсан. Монгол Улс нь тодорхойлогдсон эрсдэл дээр суурилсан МУТСТ үндэсний бодлогыг хэрэгжүүлж хараахан эхлээгүй байсан. ХАЗ (МУТСТ үндэсний бодлогыг тодорхойлох эрх бүхий байгууллага) болон ТТАЗ (Терроризмтой тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэх, хянах эрх бүхий байгууллага) нь МУТС асуудлын хүрээнд хязгаарлагдмал хамтын ажиллагаа, уялдаа холбоотой байсан бөгөөд Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх асуудлаар зохицуулалт хийгдээгүй байсан.

20. Эрсдэл дээр суурилсан Үндэсний МУТСТ хөтөлбөр (ҮХ)-ийг 2017 оны 5-р сард баталсан бөгөөд үүний дагуу ҮЗ, Санхүүгийн мэдээллийн алба (СМА) нь үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, үнэлгээ хийх үүрэгтэй бөгөөд МУТСТ стандарт, хяналт шалгалтын үр дүн болон олон улсын зөвлөмжийн дагуу хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах эрхтэй. ТТАЗ нь ТС-тэй тэмцэх үйл ажиллагааг хэрэгжүүлдэг бөгөөд ТТАЗ болон ХАЗ-ийн байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичиг (СБ) нь үүрэг, хариуцлага, хамтын ажиллагааг тодорхой тусгасан болно. ХАЗ-ийн МУТСТ тал дээрх хамтын ажиллагаа, уялдааны түвшин хязгаарлагдмал хэвээр байна.

21. ТТ тухай хууль, МУТСТ тухай хууль, УСҮАЖ, Террорист этгээдийн жагсаалтад оруулах, жагсаалтад орсон этгээдийн хөрөнгийн хөдөлгөөнийг зогсоох, хянах журамд (ТЭЖ) Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх (ҮОХЗДС) тухай тусган, нэмэлт өөрчлөлт оруулсан байна. Үүний үр дүнд эдгээр хуульд тусгагдсан уялдаа холбоо, хамтын ажиллагааны тогтолцоо нь ҮОХЗДС салбарт хэрэглэгдэж байна. ХАЗ болон ТТАЗ нь ҮОХЗДС хүрээнд хамтын ажиллагаа, мэдээлэл солилцох үйл ажиллагааг онцолсон Хамтран ажиллах санамж бичиг (ХАСБ) гарын үсэг зурсан байна.

22. СМА-ны Нууцын тухай журам (2017 оны 9-р сар) нь СМА-ны мэдээллийн санд байрлах СМА-ны мэдээллийн нууцлалыг хамгаалах зорилгоор батлагдсан бөгөөд хуулиар хатуу хориглосон мэдээллийг задруулахгүйгээр СМА-ны мэдээлэлд нэвтэрч, ашиглах бусад агентлаг болон бүх хууль сахиулах байгууллагуудад хамаарах юм. СМА нь АТГ, ЦЕГ, ТЕГ-тай мэдээллийн нууцлалыг чанд мөрдөх тухай тусгасан ХАСБ байгуулсан. Ерөнхий хамтын ажиллагаа, уялдаа холбоог ХАЗ-өөр дамжуулан зохицуулагддаг бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн яам (ХЗДХЯ), Улсын Ерөнхий Прокурорын газар (УЕПГ) нь энэхүү зөвлөлийн гишүүд юм. Нэмж дурдахад, мэдээлэл цуглуулах, ашиглах, нууцыг хамгаалах журам (2017 оны 3-р сар) нь Шүүхийн ерөнхий зөвлөл, Хууль зүй, дотоод хэргийн яам, ЦЕГ, ЕПГ, Шүүхийн шийдвэрийн ерөнхий газар (ШШЕГ)-ээс бүрдсэн гол засаг захиргааны байгууллагуудын хоорондын хамтын ажиллагаа, уялдаа холбоо, мэдээллийн нууцлалыг зохицуулдаг. Энэхүү журамд СМА-г шууд тусгаагүй ч СМА, МУТСТ-тэй холбоотой нууцын өндөр зэрэглэлийн журам, гол агентлагуудын хоорондох ХАСБ нь нууцлал, нууцын хамгаалалтыг өндөр түвшинд хангадаг болно.

23. Монгол Улс ЗӨВ.2 дээр илэрсэн дутагдлыг арилгах чиглэлээр томоохон ахиц дэвшил гаргасан байна. Монгол Улсын Засгийн газар нь эрсдэл дээр суурилсан үндэсний стратегийг 2017 оны 5-р сард баталсан. ҮОХЗДС тухай ТТ тухай хууль, МУТСТ тухай хууль, УСҮАЖ, ТЭЖ-ний журамд тусгасан бөгөөд ҮОХЗДС-ийг энэхүү хуулиудаар тодорхойлсон хамтын ажиллагаа/уялдааны тогтолцоонд хамруулсан болно. ТТАЗ нь МУТСТ үйл ажиллагааны хамтын ажиллагаа, уялдаа холбоонд хязгаарлагдмал түвшинд оролцож байна. СМА-ны мэдээллийн санд байрлах мэдээллийн нууцлалыг хамгаалах зорилгоор СМА-ны аюулгүй ажиллагааны журам батлагдсан. ХАЗ нь байгууллага хоорондын ерөнхий хамтын ажиллагаа, уялдаа холбоог хариуцдаг. МУТСТ үйл ажиллагааны хамтын ажиллагаа, уялдаа холбоонд ХАЗ хязгаарлагдмал хэмжээнд оролцож байна.

24. **Монгол Улсын ЗӨВ.2-ын үнэлгээг ахиулан Ихэнхийг биелүүлсэн (ИБ) болгов.**

Зөвлөмж 6 (Хэсэгчлэн биелүүлсэн (ХБ) үнэлгээтэй байсан)

25. Монгол улс нь ХҮТ-д ЗӨВ.6 дээр ХБ үнэлгээ авсан. Хамгийн гол дутагдал нь хөрөнгө царцаах, хөрөнгө олгохыг хориглох болон СБ, СББМҮҮ нар царцаасан хөрөнгө, хэрэгжүүлсэн арга хэмжээгээ мэдээлэх зэргийг хамарсан зорилтот санхүүгийн хориг арга хэмжээ (ЗСХА)-ний үүргээ хэрэгжүүлээгүй явдал юм. Үүнээс хойш Монгол Улс МУТСТ тухай хууль, Терроризмтой тэмцэх (ТТ) тухай хууль, ТЭЖ-ний журам, УСҮАЖ, Зөрчлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулснаар ТЭЖ-ний эрх зүйн орчин бүрдүүлсэн байна.

26. МУТСТ хууль, УСҮАЖ, ТЭЖ журамд тусгагдсан хөрөнгө царцаах, хориг тавих цогц үүргээс бүрдсэн Зорилтот санхүүгийн хориг арга хэмжээ (ЗСХАХ)-ний үүрэг одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Эдгээр үүргээ биелүүлээгүй тохиолдолд арга хэмжээ авах талаар Зөрчлийн тухай хуулинд тусгасан болно. Гэвч ТТ тухай хуулинд тусгагдсан ЗСХАХ үүрэг нь хэрэгжихгүй хэвээр байна. Гэсэн хэдий ч, ТЭЖ-ний журам нь бүх хувь хүн, хуулийн этгээдийг

бүрэн хамардаг тул энэ дутагдал нь бага гэж тооцогддог бөгөөд шаардлагатай бүх нөхцөлд ЗСХАХ-ний үүрэг нь бүрэн хэрэгжиж байна. Монгол Улсын хууль эрх зүйн хүрээнд Траст, компанийн үйлчилгээ үзүүлэгч (ТКҮҮ), Төрийн тэтгэвэр, даатгалын сангууд нь МҮЭ-д ороогүй тул С.6.5(е)-д тусгагдсан хөрөнгийг царцаах гэх мэт үүрэг нь тэдгээр байгууллагуудад хамаардаггүй байна.

27. ТЭЖ-ний журамд ТЕГ нь хөрөнгө царцаах, зарцуулах, bona fide гуравдагч этгээдийн эрхийг хамгаалах арга хэмжээг авах, жагсаалтаас хасах, хөрөнгө чөлөөлөх журам батлах шийдвэрийг гаргахдаа нэг талын санаачилгаар ажиллах шаардлагатайг тодорхой тусгасан болно. СМА нь ЗСХАХ-ний талаарх удирдамж боловсруулж, бүх МҮЭ-д хүргэсэн. Гэвч үүнд ТКҮҮ, Төрийн тэтгэвэр, даатгалын сан ороогүй болно (с.6.5 (f)).

28. Ерөнхийдөө Монгол Улс нь ЗӨВ.6-ийн техникийн хэрэгжилт дээр томоохон ахиц дэвшил гаргасан байна. Гэхдээ, ТТ тухай хуульд заасан ЗСХАХ-ний үүргийн биелэлтийг Биелүүлээгүй болон ТКҮҮ, Төрийн тэтгэвэр болон даатгалын санг МҮЭ-д хамруулаагүй зэрэг бага зэргийн дутагдал байсаар байна. ТКҮҮ, Төрийн тэтгэвэр, даатгалын сантай холбоотой дутагдлыг ХҮТ болон ЗӨВ.22-ийн дүн шинжилгээнд дурдсан шалтгааны улмаас бага гэж үзсэн.

29. **Монгол Улсын ЗӨВ.6-ын үнэлгээг ахиулан Ихэнхийг биелүүлсэн (ИБ) болгов.**

Зөвлөмж 7 (Биелүүлээгүй (БГ) үнэлгээтэй байсан)

30. Монгол улс ХҮТ-нд ЗӨВ.7 дээр Биелүүлээгүй (БГ) үнэлгээ авсан. Учир нь ҮОХЗДС-тэй холбоотой ЗСХАХ хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчин байхгүй байсан. Үүнээс хойш Монгол Улс МУТСТ тухай хууль, ТТ тухай хууль, ТЭЖ, УСҮАЖ, Зөрчлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, ҮОХЗДС-тэй холбоотой ЗСХАХ-г хэрэгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлсэн.

31. ҮОХЗДС-д хэрэгждэг ЗСХАХ-ний тогтолцоо нь терроризмд хамаарах тогтолцоотой ижил байна. МУТСТ тухай хууль болон ТТ тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлт нь терроризмтой тэмцэх тухай бүх заалтууд ҮОХЗДС-тэй тэмцэхэд мөн адил хэмжээнд хамрахаар тусгасан болно. Иймд, ТТ тухай хуульд тусгагдсан хэрэгжээгүй ЗСХАХ-ний заалттай холбоотой дутагдал нь мөн ЗӨВ.7-д хамаарна гэсэн үг юм. Гэсэн хэдий ч эдгээр дутагдал нь бага гэж тооцогдсон, учир нь тэдгээр хуулийн хүрээнд ЗСХАХ-ний зохицуулалтад оруулсан бодит нэмэлт өөрчлөлт нь ЗӨВ.7-ийн шаардлагыг дийлэнхэд нь хангаж, бүх хувь хүн, хуулийн этгээдийг хамарсан болно. ЗСХАХ-ний хууль эрх зүйн хүрээнд орсон нэмэлт өөрчлөлтүүдийн хувьд:

- ҮОХЗДС-тэй холбоотой НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл (АЗ)-ийн тодорхойлолтууд шууд хүчин төгөлдөр болно.
- Бүх хувь хүн, хуулийн этгээд нь АЗ-с тодорхойлсон хүн, аж ахуйн нэгжийн хөрөнгө, бусад хөрөнгийг цаг алдалгүй царцаах үүрэгтэй бөгөөд тэдгээр хүмүүст хөрөнгө, бусад хөрөнгийг олгохыг хориглоно.
- ТЕГ нь хяналт шалгалтын байгууллага, олон нийтэд АЗ-с тодорхойлсон хүмүүсийн талаарх мэдээллийг шууд мэдээлэх ажлыг цаг алдалгүй хийх үүрэгтэй бөгөөд үүний шинэчлэгдсэн жагсаалтыг нийтэлж, хэрэглэгчдэд хүргэх замаар гүйцэтгэнэ.
- МҮЭ нь хөрөнгийг царцаах болон тодорхойлогдсон этгээд, аж ахуйн нэгжтэй холбоотой бусад арга хэмжээний талаар мэдээлэх үүрэгтэй болно. Гэсэн хэдий ч энэ үүрэг нь ТКҮҮ, Тэтгэвэр, даатгалын сангуудад хамаардаггүй байна.
- Bona fide гуравдагч этгээдийн эрхийг хамгаалах арга хэмжээ байхгүй байна.
- Хяналт шалгалтын ажилтнууд нь тухайн салбарт ЗСХАХ-ийн үүргийн биелэлтэд хяналт тавьж, хэрэгжүүлэх үүрэгтэй. Монголбанк нь ЗСХАХ-нд хяналт тавих журамтай байна. Гэсэн хэдий ч банкнаас бусад МҮЭ-тэй холбоотой хяналт шалгалт хийх тогтолцоо нь тодорхойгүй байгаа бөгөөд МУТСТ тухай хуульд ТКҮҮ, Тэтгэвэр, даатгалын санг МҮЭ-ийн жагсаалтад хамруулаагүйн улмаас тэдэнд зориулсан хяналт шалгалт хийх, хэрэгжилтийг хангах тогтолцоо байхгүй байна.
- Нийтэд нээлттэй болгосон бүртгэлээс хасах, хөрөнгийг чөлөөлөх, зөвшөөрөл олгох журам байдаг болно.

- ЗСХАХ хүчин төгөлдөр болохоос өмнө гэрээ, хэлэлцээр, үүрэг хариуцлагын талаар данс, төлбөр тооцоо хийх нэмэлт өөрчлөлт оруулах тогтолцоо байдаг болно.

32. Ерөнхийдөө, Монгол Улс нь ЗӨВ.7-ийн хэрэгжилт дээр томоохон ахиц дэвшил гаргасан байна. СББМҮҮ-ийн ЗСХАХ-тэй холбоотой үүрэг, удирдамжийн хяналт, хэрэгжилт болон ТКҮҮ, Төрийн тэтгэвэр, даатгалын санг МҮЭ-ийн жагсаалтад оруулаагүйгээс шалтгаалсан бага зэргийн дутагдал байсаар байна. ХҮТ болон ЗӨВ.22-ийн дүн шинжилгээнд дурдсан шалтгааны улмаас ТКҮҮ, Төрийн тэтгэвэр, даатгалын сангай холбоотой дутагдлыг бага гэж үзнэ.

33. **Монгол Улсын ЗӨВ.7-ын үнэлгээг ахиулан Ихэнхийг биелүүлсэн (ИБ) болгов.**

Зөвлөмж 8 (Хэсэгчлэн биелүүлсэн (ХБ) үнэлгээтэй байсан)

34. Монгол улс ХҮТ-д ЗӨВ.8 дээр ХБ үнэлгээ авсан. ХҮТ-д дараах дутагдлууд илэрсэн: (i) Үндэсний эрсдэлийн үнэлгээ (ҮЭҮ) АББ-тай холбоотой аюул занал, эрсдэлийг зохих ёсоор үнэлээгүй, (ii) Монгол Улс нь (a) эрсдэлтэй АББ-ын талаар ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх, энэхүү арга хэмжээг дэмжих, (b) эрсдэлтэй АББ-тай шилдэг туршлагыг боловсруулах, (в) АББ-уудыг зохицуулалттай санхүүгийн сувгаар гүйлгээ хийхийг дэмжиж алхмуудыг хийгээгүй, (iii) АББ-уудын хяналт, шалгалтын түвшин тодорхой бус, (iv) АББ-ын тухай хуулийн дагуу үүргээ зөрчсөн тохиолдолд зөрчилтэй нь дүйцэхүйц, гэмт хэрэг дахин үйлдэхээс сэргийлэхүйц биш, (v) ТЕГ-ийн ТС үйл ажиллагаа явуулж байгаа гэж сэжиглэгдсэн АББ-уудыг шалгах мэдлэг, чадвар хомс; өмнө нь АББ-ын ТС-тэй холбоотой мөрдөн байцаалт явуулж байсан гэсэн ямар ч нотолгоо байхгүй байна.

35. ЗӨВ.1-т дээр дурдсанчлан, Монгол Улс ТС эрсдэлийн үнэлгээгээ саяхан шинэчилсэн. Шинэ ТС эрсдэлийн үнэлгээнд АББ-уудтай холбоотой ТС эрсдэлийн үнэлгээ багтсан бөгөөд АББ-ын салбарыг бүхэлд нь дунджаас өндөр ТС эрсдэлтэй салбар бөгөөд Монгол Улсын хувьд хамгийн өндөр эрсдэлтэй салбар гэж тодорхойлсон байна. Гэсэн хэдий ч, (i) Монгол Улс ФАТФ-ын АББ-ын тодорхойлолтод ордог дэд бүлгүүд (эрсдэлийн үнэлгээнд 505 шашны байгууллага, гадаадын АББ-ын салбар, охин компани болох 95 АББ-ыг нарийвчлан авч үзсэн болно) болон эрсдэлд өртөх өндөр магадлалтай АББ-ыг зохих хэмжээнд тодорхойлж чадаагүй бөгөөд (ii) эрсдэлд өртөх өндөр магадлалтай АББ-уудыг авах арга хэмжээний зохистой байдлыг нягтлахаар ажиллаж байна. Монгол Улс давтамжтай үнэлгээ хийх тогтолцоотой байна.

36. Монгол Улс ҮЭҮ-ний үр дүнд эрсдэлтэй гэж илэрсэн АББ-ын салбарт маш хязгаарлагдмал байдлаар хүрч ажилласан; ТС эрсдэл, эрсдэлд өртөх байдлыг арилгах шилдэг туршлагыг боловсруулж сайжруулах чиглэлээр АББ-тай хамтарч ажиллаагүй; АББ-ыг зохицуулалттай санхүүгийн сувгаар дамжуулан үйл ажиллагаа явуулахыг дэмжихгүй байна.

37. АББ-уудын хяналт, шалгалтын түвшин тодорхойгүй байна. С.8.2(а)-ийн шаардлагад нийцүүлэн АББ-ын тухай хуулийг зөрчсөн тохиолдолд зарим хориг арга хэмжээ авч байгаа боловч Зөрчлийн тухай хуульд ЗӨВ.8-ийн бусад шалгууртай холбоотой зөрчилд хориг арга хэмжээ аваагүй болно.

38. ХҮТ-с хойш Монгол Улсад үр дүнтэй мэдээлэл цуглуулах, мөрдөн байцаах (с.8.5), олон улсын мэдээлэл авах хүсэлтэд үр дүнтэй хариу өгөх (с.8.6)-тэй холбоотой шаардлагыг хэрэгжүүлэх талаар өөрчлөлт ороогүй болно.

39. Монгол Улс 2017 оны ХҮТ-нд тодорхойлсон дутагдлыг арилгах талаар хэд хэдэн алхам хийсэн боловч саяхан хийгдсэн ТС эрсдэлийн үнэлгээ нь эрсдэлтэй АББ-ыг зохих хэмжээнд тодорхойлж чадаагүй байгаа бөгөөд эрсдэлтэй АББ-д авах арга хэмжээний зохистой байдлыг шалгах үйл явц нь үргэлжилж байна. ХҮТ-д дурдагдсан бусад дутагдал байсаар байна.

40. **Монгол Улсын ЗӨВ.8-ын үнэлгээг ахиулан Ихэнхийг биелүүлсэн (ИБ) болгов.**

Зөвлөмж 14 (Хэсэгчлэн биелүүлсэн (ХБ) үнэлгээтэй байсан)

41. Монгол улс ХҮТ-д ЗӨВ.14 дээр ХБ үнэлгээ авсан. ХҮТ-нд дараах дутагдлуудыг тодорхойлсон: (i) Монгол Улс нь зөвшөөрөлгүй, бүртгэлгүй мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэгчдийг илрүүлж, шийтгэл оноосон гэсэн нотолгоо гаргаагүй бөгөөд авах боломжтой арга хэмжээ нь хоорондоо зөрчилтэй нь дүйцэхүйц, гэмт хэрэг дахин үйлдэхээс сэргийлэхүйц биш байсан; (ii) (a) ББСБ нь төлөөлөгч ашиглаж байгаа эсэх, төлөөлөгчдөд тусгай зөвшөөрөл олгох/бүртгэх шаардлагатай байгаа эсэх, эсвэл ББСБ нь өөрийн төлөөлөгчийн жагсаалтыг гаргах шаардлагатай байгаа эсэх, (б) төлөөлөгчид нь МУТСТ хөтөлбөрт хамрагдаж, хэрэгжилтэд хяналт тавьж байгаа эсэх нь бүгд тодорхойгүй байна.

42. Монгол Улс зөвшөөрөлгүй, бүртгэлгүй мөнгө гуйвуулгын үйлчилгээ үзүүлэгчидтэй холбоотой зарим арга хэмжээ авсан гэж мэдэгдсэн боловч эдгээр нь проактив (proactive) биш j-реактив (reactive) байна. Зөрчлийн тухай хуулийн 11.6-д заасан шинэ хориг арга хэмжээ (гэмт хэргээс олсон мөнгийг хураах, иргэнийг ~ 114 доллар, хуулийн этгээдийг ~ 1,140 ам. доллароор торгох зөрчилтэй нь дүйцэхүйц, гэмт хэрэг дахин үйлдэхээс сэргийлэхүйц байгаа эсэх талаар нарийвчилсан мэдээлэл өгөөгүй байна.

43. С.14.4 ба с.14.5-тай холбоотой дутагдлыг УСҮАЖ-ын 12.19-д заасны дагуу шийдвэрлэсэн байна.

44. Монгол Улс зөвшөөрөлгүй мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэгчдийг илрүүлэх, шийтгэхтэй холбоотой дутагдлыг арилгаагүй байна.

45. **Монгол Улсын ЗӨВ.14-ийн Хэсэгчилсэн биелүүлсэн (ХБ) үнэлгээг хэвээр үлдээв.**

Зөвлөмж 17 (Биелүүлээгүй (БГ) үнэлгээтэй байсан)

46. Монгол улс ХҮТ-нд ЗӨВ.17 дээр Биелүүлээгүй (БГ) үнэлгээ авсан. ХҮТ-д дараах дутагдлуудыг дурдсан: (i) гуравдагч этгээдэд тулгуурлах явдлыг зөвхөн СБ болон СББМҮҮ-дээр хязгаарлаагүй, (ii) гуравдагч этгээдэд тулгуурлах нь харилцагч, эцсийн өмчлөгч, бизнесийн мөн чанарыг тодорхойлох төдийхнөөр хязгаарлагдаж байна, (iii) ХТМ үйл ажиллагааны эцсийн үүрэг хариуцлагыг МҮЭ хүлээх зохицуулалт байхгүй, (iv) гуравдагч этгээдийн байрлах улсыг тодорхойлохдоо тухайн улсын эрсдэлийн түвшинг тодорхойлдог байх, (v) нэг санхүүгийн нэгдэлд харьяалагдах гуравдагч этгээдэд тулгуурлах зохицуулалт боловсруулах.

47. МУТСТ тухай хуулийн 5.12-т заасны дагуу СБ нь дараах УСҮАЖ-д заасан нэмэлт шаардлагыг ханган гуравдагч этгээдэд тулгуурлахыг зөвшөөрнө:

- УСҮАЖ-ын 8.1-д зааснаар МҮЭ нь үйлчлүүлэгчийг таних, эцсийн өмчлөгчийг тогтоох, бизнесийн мөн чанарыг ойлгоход гуравдагч этгээдэд тулгуурлах эрхтэй.
- УСҮАЖ-ын 8.1-д заасны дагуу МҮЭ нь хүсэлт гаргасан тохиолдолд ХТМ болон холбогдох мэдээллийг нэн даруй өгч, бэлэн байлгах ёстой.
- УСҮАЖ-ын 8.5-д заасны дагуу ХТМ үйл ажиллагааг хэрэгжүүлэх гуравдагч этгээд нь МУТСТ хяналт, ХТМ, бүртгэл хөтлөх шаардлагыг дагаж мөрдөх шаардлагатай.
- УСҮАЖ-ын 8.4-т заасны дагуу Монгол Улс МҮЭ-ийг гуравдагч этгээдтэй гэрээ байгуулахаас өмнө гуравдагч этгээдийн оршин сууж буй улстай холбоотой МУТС эрсдэлийг харгалзан үзэх шаардлагатай.
- УСҮАЖ-ын 8.6 нь с.17.3-ийн агууламжтай ижил болно.

48. Төрийн Тэтгэвэр, Даатгалын Сангийн дутагдал мөн ЗӨВ.17-д хамаарна.

49. **Монгол Улсын ЗӨВ.17-ын үнэлгээг ахиулан Ихэнхийг биелүүлсэн (ИБ) болгов.**

Зөвлөмж 19 (Хэсэгчлэн биелүүлсэн (ХБ) үнэлгээтэй байсан)

50. Монгол Улс ХҮТ-д ЗӨВ.19 дээр ХБ үнэлгээ авсан. ХҮТ-д дараах дутагдлууд дурдагдсан: (i) өндөр эрсдэлтэй орнуудад тодорхойлсон эрсдэлийн хэмжээтэй уялдуулан нарийвчилсан ХТМ үйл ажиллагаа хийх шаардлага тавиагүй байсан бөгөөд (ii) ФАТФ-аас

шаардсан тохиолдолд эсвэл ФАТФ-аас тусгайлан шаардсан бүх тохиолдолд эрсдэлийн хэмжээнд дүйцэхүйц сөрөг арга хэмжээ авах шаардлага тавиагүй.

51. МУТСТ тухай хуулийн 5.3-т заасны дагуу МҮЭ эрсдэлийг үнэлэх, өндөр эрсдэлтэй үйлчлүүлэгчдэд нарийвчилсан ХТМ үйл ажиллагаа хэрэгжүүлэх үүрэгтэй. ФАТФ-аас зарласан орнуудын иргэн, хуулийн этгээдүүд нь Өндөр эрсдэлтэй үйлчлүүлэгч юм (МУТСТ тухай хуулийн 5.9.2-р зүйл). Нарийвчилсан ХТМ арга хэмжээг МУТСТ тухай хуулийн 6 дугаар зүйлд, бизнесийн харилцаа, гүйлгээг хамарсан арга хэмжээг УСҮАЖ-ын 7 дугаар зүйлд тус тус тусгасан болно.

52. МУТСТ тухай хуулийн 6.3-т заасны дагуу УСҮАЖ-ын 7.4-т тусгасан сөрөг арга хэмжээг ФАТФ, СМА, хянан шалгагч нарын шаардлагаар хэрэгжүүлж болох бөгөөд INR19 2-р Зүйлд заасан арга хэмжээг мөн хэрэгжүүлж болно.

53. Төрийн Тэтгэвэр, Даатгалын Сангийн хувьд хяналт шалгалтад хамруулаагүй дутагдал байсаар байна (Монгол Улс ЗӨВ.1-ийн дагуу эрсдэл багатай тохиолдолд хэрэгжүүлэх арга хэмжээг авч хэлэлцээгүй боловч ХҮТ-нд тусгагдсан Төрийн Тэтгэвэр, даатгалын санг үнэлгээний багаас эрсдэл багатай гэж үзэж байна).

54. Монгол Улсын ЗӨВ.19 -ын үнэлгээг ахиулан Ихэнхийг биелүүлсэн (ИБ) болгов.

Зөвлөмж 21 (Хэсэгчлэн биелүүлсэн (ХБ) үнэлгээтэй байсан)

55. Монгол Улс ХҮТ-д ЗӨВ.21 дээр ХБ үнэлгээ авсан. ХҮТ-д дурдагдсан дутагдал нь: (i) "банк ба мэргэжлийн нууцлал" гэсэн тодорхойлолт нь иргэний болон эрүүгийн хариуцлагаас аль алинаас чөлөөлдөг эсэх нь тодорхойгүй бөгөөд УСҮАЖ-ын 12.1, 12.2-р заалтууд нь зөвхөн МҮЭ-д хамаарах бөгөөд МҮЭ-ийн захирал, албан хаагч, ажилтанд хамаарахгүй, (ii) СМА-нд мэдээлэх журам нь зөвхөн банк, түүний захирал, ажилтан, албан хаагчдаар хязгаарлагддаг бөгөөд банкнаас бусад МҮЭ-ийн захирал, албан тушаалтан, ажилтнуудад хуулинд заасан хориг арга хэмжээ байдаггүй.

56. МУТСТ тухай хуулийн 12.1, 12.2-т банк, мэргэжил, үйлчлүүлэгч, арилжааны байгууллага, бизнесийн болон нууцлалын бусад шаардлагыг биелүүлэхгүй байх, иргэний/эрүүгийн хуулийн харицлагаас чөлөөлөх талаар тусгасан байна. Эдгээр заалтыг УСҮАЖ-ын 19.3-т удирдлага, захирал, албан хаагч, түнш, мэргэжлийн хүмүүс эсвэл ажилчдыг хамруулан илүү нарийвчлан тодорхойлсон болно.

57. МУТСТ тухай хуулийн 13.1-т МҮЭ, түүний удирдлага, ажилчдад СГТ болон бусад холбогдох мэдээллийг СМА, бусад байгууллагуудад хүргүүлсэн талаар задруулахыг хориглодог. Энэхүү заалтуудыг УСҮАЖ-ын 19.1-д захирлууд, албан хаагчид, ажилтнуудыг тусгайлан оруулахаар тусгайлан заасан болно.

58. Монгол Улсын ЗӨВ.21-ийн үнэлгээг ахиулж Бүрэн биелүүлсэн (ББ) болгов.

Зөвлөмж 22 (Биелүүлээгүй (БГ) үнэлгээтэй байсан)

59. Монгол Улс ХҮТ-д ЗӨВ.22 дээр БГ үнэлгээ авсан. ХҮТ-д дурдагдсан дутагдлууд нь: (i) МУТСТ шаардлага СББМҮҮ-дээс зөвхөн нотариатчдад хамаарах тул МУТСТ хууль явцуу хүрээнд үйлчилж байна;(ii) Зөвлөмж 12, 15, 17-той холбоотой цуврал дутагдал, доголдол оршиж байна.

60. ХҮТ-с хойш Монгол Улс СББМҮҮ-д зориулсан шинэ МУТСТ хууль, эрх зүйн орчинг нэвтрүүлсэн. МУТСТ тухай хуулийн 4-т заасны дагуу ТКҮҮ-с бусад бүх СББМҮҮ нь МҮЭ болсон бөгөөд МУТСТ шаардлагыг хэрэгжүүлэх үүрэгтэй болсон. ХҮТ дээр дурдсанчлан казино хууль бус байгаа. Үл хөдлөх хөрөнгийн зуучлагчид, үнэт металл, чулууны наймаа эрхлэгчид (20 сая төгрөг~\$7,628 ам.долларын босго хэмжээ), нотариатчид, хуульч, нягтлан бодогчид болон бусад санхүүгийн менежментийн зөвлөхүүд МУТСТ хууль, УСҮАЖ, ХТМ-тэй холбоотой шаардлагыг хэрэгжүүлэх үүрэгтэй болсон. С.18.18-т заасан шаардлага дутмаг, с.10.16 ба с.10.20-

т тавигдах шаардлага байхгүйг эс тооцвол МУТСТ хууль, УСҮАЖ нь ХТМ бүх үүргийг тусгасан байна.

61. МУТСТ тухай хуулийн 8.1, 8.2-р зүйл, УСҮАЖ-ын 15.1, 15.2-т заасны дагуу ТКҮҮ-ээс бусад бүх СББМҮҮ нь ЗӨВ.11-ийн бүртгэл хөтлөх үүрэг хүлээсэн.

62. ТКҮҮ-с бусад бүх СББМҮҮ-ид ЗӨВ.12-ийн дагуу улс төрд нөлөө бүхий этгээд (УТНБЭ)-эд хэрэгжүүлэх арга хэмжээг авах шаардлагатай (УСҮАЖ-ын 6-р зүйл). Гэсэн хэдий ч УТНБЭ-ийн тодорхойлолт (МУТСТ тухай хуулийн 3.1.5-р зүйл)-д цэргийн албан тушаалтан, улс төрийн намуудын чухал албан тушаалтнуудыг оруулаагүй байна.

63. ТКҮҮ-ээс бусад бүх СББМҮҮ-ууд шинэ буюу хөгжиж буй технологийн эрсдэлийг бууруулах талаар журамтай байх ёстой бөгөөд нэвтрүүлэхээс өмнө эрсдэлийн үнэлгээ хийх үүрэгтэй байна.

64. ТКҮҮ-ээс бусад бүх СББМҮҮ нь ЗӨВ.17-ийн шаардлагыг дагаж мөрдөх үүрэгтэй болно (дээрх хэлэлцүүлгийг үзнэ үү).

65. ТКҮҮ-с бусад (Монгол Улс ЗӨВ.1-т заасны дагуу эрсдэл багатай тохиолдлыг хэрэгжүүлэх оролдлого хийгээгүй боловч ХҮТ-ийн дагуу үнэлгээний баг ТКҮҮ байгууллагуудыг эрсдэл багатай гэж үзсэн) бүх СББМҮҮ-ууд нь МУТСТ МҮЭ-д ордог бөгөөд МУТСТ тухай хууль ба УСҮАЖ-нд заасан шаардлагыг хэрэгжүүлэх үүрэгтэй. ХТМ ба УТНБЭ-тэй хамааралтай бага зэргийн дутагдал байсаар байна.

66. Монгол Улсын ЗӨВ.22-ийн үнэлгээг ахиулж Ихэнхийг биелүүлсэн (ИБ) болгов.

Зөвлөмж 23 (Биелүүлээгүй (БГ) үнэлгээтэй байсан)

67. Монгол Улс ХҮТ-д ЗӨВ.23 дээр Биелүүлээгүй (БГ) үнэлгээ авсан. МУТСТ шаардлага СББМҮҮ-ээс зөвхөн нотариатчдад хамааралтай тул МУТСТ хууль явцуу хүрээнд үйлчилж байна. Зөвлөмж 18, 19, 20, 21-тэй холбоотой цуврал дутагдал, доголдол оршиж байна гэсэн дутагдал ХҮТ-д илэрсэн.

68. Дээр дурдсанчлан, МУТСТ тухай хуулийн 4.1-т заасны дагуу ТКҮҮ-ээс бусад бүх СББМҮҮ нь МҮЭ-ийн жагсаалтад ордог бөгөөд МУТСТ шаардлагыг хэрэгжүүлэх үүрэгтэй (Казино нь хууль бус).

69. ТКҮҮ-с бусад бүх СББМҮҮ-ууд СГТ (МУТСТ тухай хуулийн 7-р зүйл) илгээж, МУТСТ дотоод хяналтыг хэрэгжүүлэх үүрэгтэй (МУТСТ тухай хуулийн 14-р зүйл, УСҮАЖ-ын 11, 16.1-16.2-р зүйл) боловч 18.2 (b)-д тавигдсан шинэ элементийг хэрэгжүүлэх шаардлага байхгүй байна.

70. ТКҮҮ-ээс бусад бүх СББМҮҮ-ид өндөр эрсдэлтэй улс орнуудад нарийвчилсан ХТМ, хариу арга хэмжээ авах үүрэгтэй (МУТСТ тухай хуулийн 6.3-р зүйл, УСҮАЖ-ын 7.4-р зүйл) боловч МУТСТ тогтолцоо нь харьцангуй сул улс орны талаар СББМҮҮ-д мэдээлэх арга хэмжээ хэрэгжүүлж байгаа эсэх нь тодорхойгүй байна.

71. СББМҮҮ нь ЗӨВ.21-ийн шаардлагыг хэрэгжүүлэх үүрэгтэй байна (дээрх хэлэлцүүлгийг үзнэ үү).

72. ТКҮҮ-с бусад (Монгол Улс ЗӨВ.1-т заасны дагуу эрсдэл багатай тохиолдлыг ашиглахыг оролдоогүй боловч ХҮТ-ийн дагуу үнэлгээний баг ТКҮҮ-г эрсдэл багатай гэж үзсэн) бүх СББМҮҮ-ууд нь МУТСТ МҮЭ-д багтдаг бөгөөд МУТСТ тухай хууль ба УСҮАЖ-нд заасан шаардлагыг хэрэгжүүлэх үүрэгтэй. ХТМ ба УТНБЭ-тэй хамааралтай бага зэргийн дутагдал байсаар байна.

73. Монгол Улсын ЗӨВ.23-ийн үнэлгээг ахиулж Ихэнхийг биелүүлсэн (ИБ) болгов.

Зөвлөмж 24 (Хэсэгчлэн биелүүлсэн (ХБ) үнэлгээтэй байсан)

74. ЭӨ-ийн мэдээллийг бүртгэж баталгаажуулах шаардлага тавиагүй байсан бөгөөд ЭӨ-ийг тогтоох үйл ажиллагаа хийгдээгүйн улмаас Монгол Улс ХҮТ-д ЗӨВ.24 дээр Хэсэгчлэн биелүүлсэн үнэлгээ авсан. Түүнчлэн, Монгол Улс эрсдэлийн үнэлгээг хуулийн этгээдийн төрлөөр гүйцэтгээгүй бөгөөд Зөвлөмж 24-т хамаарах зөрчилд ногдуулах шийтгэл нь гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхүйц биш байсан. Гадаад улс орнуудаас ирүүлж буй ЭӨ-ийн талаарх мэдээллийн чанарыг шалгах тогтолцоо Монгол Улсад мөн байхгүй байсан.

75. ХҮТ-ээс хойш Монгол Улс хуулийн этгээдийн үйл ажиллагааг харгалзан хэд хэдэн салбарын эрсдэлийн үнэлгээг хийсэн боловч хуулийн этгээдийн төрлөөр нь ялгаж эрсдэлийг үнэлээгүй байна. Эдгээр эрсдэлийн үнэлгээ нь үйл ажиллагааны төрлөөс хамаарсан тодорхой төрлийн хуулийн этгээдийн хувьд үүсч болох зарим эрсдэлийг ойлгоход тусалж болох ч с.24.2-т заасан шаардлагыг биелүүлээгүй хэвээр байна.

76. Одоогоор Улсын бүртгэлийн ерөнхий газар (УБЕГ)-т ирүүлсэн мэдээллийн үнэн зөв эсэхийг шалгах тогтолцоо хэрэгжиж байна. Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан нь дараах үүргийг хэрэгжүүлэхэд томоохон ач холбогдол үзүүлсэн:

- Хуулийн этгээдийг бүртгэх эсвэл одоо байгаа хуулийн этгээдийн мэдээлэлд өөрчлөлт оруулахдаа үнэн, бодит зөв мэдээллийг УБЕГ-т ирүүлэх үйл ажиллагаа (14.4.-р Зүйл);
- УБЕГ-д ирүүлсэн мэдээллийн үнэн зөв, бодит эсэхийг шалгаж, баталгаажуулах (16.1.7., 19.4.1-р зүйл) бөгөөд мэдээллийн санд бүртгэх үйл ажиллагаа (11.1., 11.2-р зүйл).

77. ЭӨ-ийн мэдээллийг агуулсан мэдээллийг цуглуулж, бүртгүүлэх (Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 10.1.14-р зүйл) бөгөөд тэдгээр мэдээллийг байнга шинэчлэх (Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 9-р зүйл) ёстой.

78. Хуулийн этгээд нь УБЕГ-т бүртгүүлэхдээ эцсийн өмчийг тодорхойлох талаар МУТС хуульд заасан хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд зөрчлийн тухай хуулийн дагуу арга хэмжээ авна. Энэ зөрчлд ногдуулах арга хэмжээ нь Монголын эдийн засгийн хувьд зөрчилтэй нь дүйцэхүйц, дахин үйлдэхээс сэргийлсэн байна гэж үзлээ.

79. Улсын бүртгэлийн ерөнхий хууль нь УБЕГ-ыг Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээний үндсэн дээр бүртгэлийн мэдээллийг хуваалцах чиглэлээр гадаадын түншүүдтэй хамтран ажиллах эрх зүйн үндсийг бий болгожээ. Гэсэн хэдий ч Монгол Улс нь бусад улс орнуудаас үзүүлж буй тусламжийн чанарт хяналт тавьж байгаа эсэхээ нотлоогүй байна.

80. Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Зөрчлийн тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтүүд нь ХҮТ-д тодорхойлсон зарим дутагдлыг арилгасан байна. Хуулийн этгээдийн төрлөөр нь ялгасан МУТС эрсдэлийн үнэлгээ байхгүй, үндсэн ЭӨ-ийн мэдээлэл авах хүсэлтийн хариуд гадаад улсаас хүлээн авсан тусламжийн чанарт хяналт тавихгүй байгаа нь бага дутагдалд тооцогдоно.

81. **Монгол Улсын ЗӨВ.24-ийн үнэлгээг ахиулж Ихэнхийг биелүүлсэн (ИБ) болгов.**

Зөвлөмж 25 (Хэсэгчлэн биелүүлсэн (ХБ) үнэлгээтэй байсан)

82. Монгол Улс ХҮТ-д ЗӨВ.25 дээр ХБ үнэлгээ авсан. Учир нь зөвхөн мэргэжлийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллаж буй нотариатчид МУТСТ хууль болон УСҮАЖ-ын ХТМ, мэдээлэл хадгалах шаардлагыг биелүүлэх үүрэгтэй тул СББМҮҮ-ийг бүрэн хамарч чадахгүй байсан. Түүнчлэн, энэхүү шаардлагын зөрчилд хүлээлгэх хариуцлага нь зөрчилд нь дүйцэхүйц, урьдчилан сэргийлэхүйц байж чадахгүй байна. Бизнесийн харилцаа холбоо үүсгэх эсхүл босго дүнгээс хэтэрсэн гүйлгээ хийх үед гадаадын итгэмжлэгдсэн төлөөлөгч нь СБ буюу СББМҮҮ-ид статусаа тайлагнах албагүй байна.

83. 2017 оноос хойш одоогийн байдлаар УСҮАЖ-нд оруулсан өөрчлөлт (13.1-р зүйл) нь итгэмжлэгдсэн төлөөлөгчдийг аливаа бизнесийн харилцаа тогтоох, эсвэл МУТСТ тухай хуулийн

7.1-т заасан босго хэмжээнээс давсан аливаа гүйлгээ хийхээс өмнө аливаа МҮЭ-д итгэмжлэгдсэн төлөөлөгчийн статусаа танилцуулах үүрэгтэй болгов. Энэхүү статусаа МҮЭ-д итгэмжлэгчид мэдээлээгүй тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн 11.29.2-т зааснаар шийтгэл хүлээхээр болов.

84. СББМҮҮ-тэй холбоотой асуудлыг МУТСТ тухай хууль (4.1.7-4.1.9-р зүйл)-нд өөрчлөлт оруулж ТКҮҮ-с бусад бүх байгууллагыг хамруулан арилгав.

85. УСҮАЖ болон МУТСТ тухай хуулинд оруулсан нэмэлт өөрчлөлтүүдийг харгалзаж үзэн ТКҮҮ-тэй холбоотой асуудлыг жижиг дутагдалд тооцогдсон.

86. **Монгол Улсын ЗӨВ.25-ын үнэлгээг ахиулж Ихэнхийг биелүүлсэн (ИБ) болгов.**

Зөвлөмж 26 (Хэсэгчлэн биелүүлсэн (ХБ) үнэлгээтэй байсан)

87. Монгол Улс ХҮТ-д ЗӨВ.26 дээр Хэсэгчлэн биелүүлсэн үнэлгээ авсан. ХҮТ-д дараах дутагдал илэрсэн: (i) Монгол Улсад халхавч банк үүсгэн байгуулахыг бүрэн хориглоогүй; (ii) гэмт хэрэгтнүүд, тэдний хамсаатнууд СБ-ын удирдлагад орох, СБ-ын үлэмж буюу хяналтын багцыг эзэмших (эсвэл ЭӨ байх)-ээс урьдчилан сэргийлэх тогтолцоо төгөлдөржөөгүй; (iii) үнэт цаас ба даатгалын СБ нь IOSCO/IAIS-ийн холбогдох үндсэн зарчимд нийцүүлэн МУТСТ хүрээнд бүрэн зохицуулагдаж, хяналтад ороогүй; (iv) ББСБ нь СБ эсвэл СБ-ын бүлгийн шинж чанар, ялангуяа төрөл болон тоо, ЭСА дээр суурилсан МУТСТ хяналт шалгалтын давтамж/цар хүрээнд хамрагдахгүй байна; (v) СБ-ын удирдлага болон үйл ажиллагаанд томоохон өөрчлөлт, хөдөлгөөн гарах үед МУТС эрсдэлийн үнэлгээг зайлшгүй гүйцэтгэх заалт байхгүй байна.

88. Халхавч банкнуудыг ФАТФ-ын стандартын дагуу МУТСТ тухай хуулийн 3.1.7-р зүйлд тодорхойлсон хэдий ч Монгол Улсад халхавч банк үүсгэн байгуулахыг бүрэн хориглоогүй (Банкны тухай хуулийн 2.1.1.2-р зүйл, УСҮАЖ-ын 1.5-р зүйл).

89. Банкууд нь гэмт хэрэгтнүүд болон тэдний хамсаатнуудад их хэмжээний буюу хяналтын багцыг эзэмших, эсвэл удирдлагын үүргийг эзэмшихээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдэд хамрагдахаар болов (Банкны тухай хуулийн 36.1, 36.5-р зүйлүүд / Хуулийн хавсралт 45).

90. ББСБ-ын тухайд Монгол Улс ихэнх банк бус санхүүгийн байгууллагуудад үлэмж буюу хяналтын багц, удирдлагын эрхийг эзэмшүүлэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан. Түүнчлэн, СЗХ нь хүсэлт гаргаж буй хуулийн этгээд/иргэн Монгол Улсын болон гадаад улсын хууль тогтоомж, дүрэм, журам, бизнесийн ёс зүйг зөрчихөд бусдад туслалцаа үзүүлж байгаа эсэхийг нарийвчлан шалгах үүрэгтэй байдаг тул даатгалын компаниудын хувьд амжилттайгаар эрүүгийн гэмт хэрэгт оролцогчдоос урьдчилан сэргийлж байна (Зохистой байдлын шалгуурын зааварчилгааны талаарх 3.1, 3.1.6-р зүйл). Гэсэн хэдий ч бусад ББСБ-уудын хувьд эрүүгийн гэмт хэргийн хамсаатнуудад хяналт тавих тогтолцоо байхгүй байна.

91. Монгол Улс МУТСТ зохицуулалт, хяналт шалгалтад Базелийн үндсэн зарчмуудыг (банкууд) хэрэгжүүлж байгаагаа харуулсан. Харин МУТСТ зохицуулалт, хяналт шалгалтад IOSCO-ийн үндсэн зарчим (үнэт цаас) болон IAIS-ийн үндсэн зарчим (даатгал)-ыг бүрэн хэрэгжүүлж байгаа эсэх нь тодорхойгүй байна. Гэсэн хэдий ч үнэлгээний баг нь Монголбанк, СЗХ хамтран 14 СБ-д нэгдсэн хяналт шалгалт хийснийг үнэлж байна.

92. Монгол Улс нь СБ эсвэл групптэй холбоотой бодлого, дотоод хяналт, журам, МУТС эрсдэл дээр суурилан МУТСТ зайнаас болон газар дээрх хийх хяналт шалгалтын давтамж, хүрээг тодорхойлсон (Мөнгө угаах, терроризмыг болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх банкны үйл ажиллагаанд газар дээрх хяналт, шалгалт хийх журмын 1.1 ба 1.2.3-р зүйл). Гэсэн хэдий ч ББСБ-уудын хувьд МУТСТ хяналт нь хүрээ болон давтамжийг СБ эсвэл бүлгийн шинж чанараар хэрхэн тодорхойлдог нь тодорхойгүй байна.

93. Банкны хянан шалгагчид нь томоохон үйл явдал, өөрчлөлтийн хариуд банкны МУТС эрсдэлийн үнэлгээг хянаж, шинэчлэх шаардлагатай болно (шинэчлэгдсэн Мөнгө угаах, терроризмыг болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх банкны үйл ажиллагаанд газар дээрх хяналт, шалгалт хийх журмын 3.6-р зүйл). ББСБ нь удирдлагын

өөрчлөлтийн талаар мэдээлэх үүрэгтэй боловч томоохон үйл явдал эсвэл бизнесийн өргөжилтийн талаар хянан шалгагчдад мэдээлэх үүрэгтэй эсэх нь тодорхойгүй байна. Шаардлагатай хэлбэрээр цуглуулсан мэдээлэл нь МУТС эрсдэлд нөлөөлж болзошгүй өөрчлөлтийг тусгасан эсэх нь тодорхойгүй байна.

94. Төрийн Тэтгэвэр, Даатгалын Сантай холбоотой дутагдалтай байна (Монгол Улс ЗӨВ.1-ийн дагуу эрсдэл багатай тохиолдолд хэрэгжүүлэх арга хэмжээг авч хэлэлцээгүй боловч ХҮТ-нд тусгагдсан Төрийн Тэтгэвэр, даатгалын санг үнэлгээний багаас эрсдэл багатай гэж үзэж байна).

95. ББСБ-ын хувьд даатгалаас бусад тохиолдолд эрүүгийн гэмт хэргийн хамсаатнуудад тавих зохистой байдлын шалгуур хязгаарлагдмал байна; үнэт цаас, даатгалд МУТСТ чиглэлээр хийсэн хяналт шалгалт нь бүх үндсэн зарчимд нийцэж байгаа эсэх нь тодорхойгүй байна; томоохон үйл явдал, өөрчлөлт тохиолдоход СЗХ-ноос ББСБ-уудын МУТС эрсдэлийн профайлыг шинэчлэх шаардлагатай эсэх нь тодорхойгүй байна.

96. **Монгол Улсын ЗӨВ.26-ын үнэлгээг ахиулж Ихэнхийг биелүүлсэн (ИБ) болгов.**

Зөвлөмж 28 (Биелүүлээгүй (БГ) үнэлгээтэй байсан)

97. Монгол Улс ХҮТ-д ЗӨВ.28 дээр Биелүүлээгүй (БГ) үнэлгээ авсан. ХҮТ-д дараах дутагдлууд дурдагдсан: (i) зөвхөн нотариатчид МУТСТ шаардлагыг хэрэгжүүлэх үүрэгтэй байсан нь СББМҮҮ-ийн хамрах цар хүрээ дутмаг байгааг харуулж; (ii) үл хөдлөх хөрөнгөөс бусад салбарт зориулагдсан МУТСТ хянан шалгагч байхгүй, (iii) СББМҮҮ-ийн МУТСТ-ийн хэрэгжилтэд хяналт тавих тогтолцоо байхгүй; МУТСТ хэрэгжилтэд хяналт тавих эрхтэй газар нь зөвхөн СМА-аар хязгаарлагдаж, СМА нь зөвхөн үл хөдлөх хөрөнгийн зуучлагч, нотариатчдад хяналт тавьдаг бөгөөд хориг арга хэмжээ нь зөрчилтэй нь дүйцэхүйц, гэмт хэрэг дахин үйлдэхээс сэргийлэхүйц биш байна (iv) СББМҮҮ-ид МУТСТ тухай хууль, УСҮАЖ-ын хяналт шалгалтад хамрагдахгүй байна.

98. ЗӨВ.22-т дурдсанчлан ТКУҮ-с бусад бүх СББМҮҮ нь МҮЭ-ийн жагсаалтад ордог бөгөөд МУТСТ шаардлагыг хэрэгжүүлэх үүрэгтэй (казино нь хууль бус). МУТСТ тухай хуулийн 19.1-т заасны дагуу Санхүүгийн Зохицуулах Хороо нь үл хөдлөх хөрөнгийн зуучлагчдыг хариуцсан МУТСТ хяналт шалгалтын байгууллага бол бусад СББМҮҮ-ийг хариуцсан хяналт шалгалтын байгууллага нь "тусгай зөвшөөрөл олгох байгууллага, хянагч" нар байна. Хэдийгээр нотариатч, хуульч, нягтлан бодогчдын хяналт шалгалтын байгууллага нь тодорхой байгаа боловч үнэт метал, чулууны худалдаа эрхлэгчдийн МУТСТ хяналт шалгалтыг СМА нь хариуцсан явдал нь ойлгомжгүй байна. Учир нь СМА нь тэдгээр байгууллагуудад тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага биш болно.

99. МУТСТ тухай хуулийн 19.2, 19.3-т заасны дагуу СББМҮҮ-ийн хянан шалгагчид МУТСТ тухай хуулийг хэрэгжүүлэх, хяналт тавих, энэ үүргээ гүйцэтгэхэд хангалттай эрх мэдэлтэй байна. МУТСТ тухай хуулийн 23.1-23.3-т заасны дагуу СББМҮҮ-ийн хянан шалгагчид Зөрчлийн тухай хуульд заасны дагуу зөрчилтэй нь дүйцэхүйц, гэмт хэрэг дахин үйлдэхээс сэргийлэхүйц арга хэмжээ авах эрх мэдэлтэй байна (ЗӨВ.25-ыг харна уу). ХҮТ-д дурдсанчлан гэмт хэрэгтнүүд нотариатч, өмгөөлөгч болохоос урьдчилан сэргийлэх хязгаарлагдмал хуулийн заалтууд байна. Харин гэмт хэрэгтнүүд болон хамсаатнууд үл хөдлөх хөрөнгийн салбарт болон үнэт металл, чулууны худалдаа эрхлэгч, нягтлан бодогчийн мэргэжлийн магадлан итгэмжлэл авахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ байхгүй байна.

100. МУТСТ тухай хуулинд СББМҮҮ-д эрсдэлийн түвшингээс хамаарсан хяналт шалгалт хийхийг тусгасан бөгөөд Монгол Улс бүх СББМҮҮ-ийн хяналт шалгалтад зориулсан зааварчилгаатай боловч Монгол Улс эрсдэлийн түвшингээс хамаарсан МУТСТ хяналт шалгалт хийх эхний шатандаа явж байна. Харин гэмт хэрэгтнүүд болон хамсаатнууд үл хөдлөх хөрөнгийн салбарт болон үнэт металл, чулууны худалдаа эрхлэгч, нягтлан бодогчийн мэргэжлийн магадлан итгэмжлэл авахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ байхгүй байна.

101. ТКУҮ-с бусад бүх СББМҮҮ нь МҮЭ-ийн жагсаалтад ордог. Монгол Улсад үнэт металл, чулууны худалдаа эрхлэгчдээс бусад бүх СББМҮҮ-г хариуцсан МУТСТ хянан шалгагч

томилогдсон бөгөөд хянан шалгагчид зүй ёсны хууль эрх зүйн орчинд хяналт, шалгалт хийх, хориг арга хэмжээ авах эрх зэрэг МУТСТ хяналт шалгалтын тогтолцоотой байна. Гэхдээ гэмт хэрэгтнүүд болон хамсаатнуудад мэргэжлийн магадлан итгэмжлэл олгохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ зөвхөн нотариатчид болон хульчдаар хязгаарлагдаж байгаа бөгөөд Монгол Улс эрсдэлийн түвшингээс хамаарсан МУТСТ хяналт шалгалтыг хэрэгжүүлэх харахан болоогүй байна.

102. Монгол Улсын ЗӨВ.28-ийн үнэлгээг ахиулж Хэсэгчлэн биелүүлсэн (ХБ) болгов.

Зөвлөмж 29 (Хэсэгчлэн биелүүлсэн (ХБ) үнэлгээтэй байсан)

103. Монгол Улс Харилцан үнэлгээний тайлан дээр Зөвлөмж 29-ийг Хэсэгчлэн биелүүлсэн үзүүлэлттэй байсан бөгөөд СМА нь арилжааны банкуудаас нэмэлт мэдээлэл авч ашигладаг хэдий ч стратеги шинжилгээ хийдэггүй гэсэн сул талтай байсан.

104. Монгол Улсын МУТСТ тухай хуульд 2018 оруулсан нэмэлт өөрчлөлтөөр тус хуулийн 16 дугаар зүйлийн дагуу СМА-ны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийг СМА-ны дарга баталдаг болсон. Мөн СМА нь бүх мэдээлэх үүрэгтэй этгээдээс нэмэлт мэдээлэл, авч ашигладаг (МУТСТ тухай хуулийн 9.2 дугаар зүйл) болсон бөгөөд эхний стратеги шинжилгээний тайланг 2018 онд хийж гүйцэтгэсэн.

105. Монгол Улсын ЗӨВ.29-ийн үнэлгээг ахиулж Ихэнхийг биелүүлсэн (ИБ) болгов.

Зөвлөмж 32 (Хэсэгчлэн биелүүлсэн (ХБ) үнэлгээтэй байсан)

106. Монгол Улс ХҮТ-д Зөвлөмж 32-ийг Хэсэгчлэн биелүүлсэн үзүүлэлттэй байсан бөгөөд дараах үзүүлэлт дээр сул талтай байсан: (i) Гаалийн декларацийн системд дотоод, гадаад валют болон МТХ-ыг хамруулах систем нь Монгол Улсын зөвхөн 1 олон улсын онгоцны буудалд хэрэгжиж байгаа бөгөөд тодруулгын систем нь бүх хилийн боомтуудад хэрэгжиж байгаа ч энэ нь МТХ-үүдийг хамардаггүй, (ii) авах захиргааны арга хэмжээ нь дахин үйлдэхээс сэргийлэхүйц биш, (ii) Гаалийн байгууллага нь худал мэдүүлсэн валют, МТХ-үүдийг саатуулж болох эсэх нь тодорхойгүй байна.

107. Монгол Улс нь декларацийн системийг бүх хилийн боомтуудад хэрэгжүүлдэг болсон байна.

108. Монгол Улсын декларацийн системийг хамарсан шийтгэлийн арга хэмжээ нь Зөрчлийн хуулийн 11.29.22-р зүйлийн дагуу гаргасан зөрчилтэй нь дүйцэхүйц болон дахин үйлдэхээс сэргийлэхүйц байгаа хэдий ч Монгол Улсын тодруулгын системийг хамарсан шийтгэлийн тогтолцоонд өөрчлөлт оруулаагүй байна.

109. Гаалийн байгууллага нь Гаалийн тухай хуулийн дагуу өргөн эрх мэдэлтэй ч Гаалийн байгууллага нь худал мэдүүлсэн валют, МТХ-үүдийг саатуулж болохтой холбоотой ямар нэг тодруулгыг Монгол Улсын зүгээс өгөөгүй болно.

110. Монгол Улсын ЗӨВ.32-ын үнэлгээг ахиулан Ихэнхийг биелүүлсэн (ИБ) болгов.

Зөвлөмж 33 (Хэсэгчлэн биелүүлсэн (ХБ) үнэлгээтэй байсан)

111. Монгол Улс Харилцан үнэлгээний тайлан дээр Зөвлөмж 33-ыг Хэсэгчлэн биелүүлсэн үзүүлэлттэй байв. Монгол Улс ялангуяа СМА нь статистикийн тайлан мэдээ гаргадаг хэдий ч МУТСТ үр дүнтэй байдлыг хангахуйц иж бүрэн тоо мэдээ, тогтолцоо байхгүй бөгөөд энэ асуудлыг эрх бүхий байгууллагуудын түвшинд зохицуулсан хууль тогтоомж байхгүй.

112. 2017 онд Монгол Улсын Эрүүгийн хууль, ЭХХШХ, ЗТХ болон ЗШШТХ-нд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр УЕПГ-ын дэргэд эрх бүхий байгууллагуудын цуглуулсан гэмт хэргийн төрөл, мөрдөн шалгах ажиллагааны үе шат болон ял шийтгэлийн мэдээллийг агуулсан нэгдсэн бүртгэлийн мэдээллийн сантай байхаар заасан. Тус бүртгэлийн нэгдсэн сан нь ХСБ-ууд

хоорондоо мэдээлэл солилцох боломжоор хангадаг бөгөөд бүх ХСБ-уудын 2018 оны 6 дугаар сараас хойш цугларсан бүх өгөгдлийг хадгалдаг байна.

113. СМА нь олон улсын стандартад нийцсэн өгөгдөл цуглуулах маягтыг боловсруулсан. Өгөгдөл цуглуулах болон мэдээлэл солилцох зохицуулалтыг тусгасан журмыг боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулсан бөгөөд одоогийн байдлаар холбогдох байгууллагуудад шаардлагатай мэдээллүүдийг цуглуулах ажил хийгдэж байна.

114. Сүүлийн үеийн статистик мэдээллийг өгөөгүй ч, одоогийн хууль тогтоомж, бүртгэлийн нэгтгэсэн мэдээллийн сангийн хөгжүүлэлт, ажлын хэсгийн хамтын ажиллагаа зэрэг нь Зөвлөмж 33-ын дагуу сайжирсан.

115. **Монгол Улсын ЗӨВ.33-ын үнэлгээг ахиулан Ихэнхийг биелүүлсэн (ИБ) болгов.**

Зөвлөмж 34 (Хэсэгчлэн биелүүлсэн (ХБ) үнэлгээтэй байсан)

116. Монгол Улс Харилцан үнэлгээний тайлан дээр Зөвлөмж 34-ийг Хэсэгчлэн биелүүлсэн үзүүлэлттэй байв. Монгол Улсад МҮЭ-үүдийг МУТСТ үүргээ биелүүлэхэд туслах зорилгоор хэд хэдэн бичиг баримтыг боловсруулсан хэдий ч тухайн үед Монгол Улсын хуулийн тогтолцоо нь СББМҮҮ-дийг МҮЭ-ийн нэгэн адил хамруулдаггүй байсан тул СББМҮҮ нарт зориулан гаргасан удирдамж, чиглэл байхгүй байсан аж.

117. 2017 оноос хойш СМА, МБ болон СЗХ нь СББМҮҮ болон бусад МҮЭ-дийг хамруулсан “Банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдүүдэд зориулсан урьдчилан сэргийлэх гарын авлага” зэрэг хэд хэдэн гарын авлагуудыг боловсруулав. СМА нь мөн хэд хэдэн салбаруудад үйл ажиллагаа эрхэлдэг МҮЭ-ийг хамарсан сургалт, уулзалтыг зохион байгуулан хүлээн авч буй тайлангуудын чанартай холбоотойгоор мэдээллийг өгч, эргэх холбоотой ажиллав.

118. Монгол Улс нь Зөвлөмж 34-ийн үнэлгээг эрс сайжруулав.

119. **Монгол Улсын ЗӨВ.34-ийн үнэлгээг ахиулан Ихэнхийг биелүүлсэн (ИБ) болгов.**

Зөвлөмж 35 (Хэсэгчлэн биелүүлсэн (ХБ) үнэлгээтэй байсан)

120. Монгол Улс Харилцан үнэлгээний тайлан дээр Зөвлөмж 35-ыг Хэсэгчлэн биелүүлсэн үзүүлэлттэй байв. Монгол Улсад нэвтрүүлсэн шийтгэлийн зарим арга хэмжээ нь гаргасан зөрчилтэй нь дүйцэхүйц, давтан үйлдэхээс сэргийлэхүйц байж чадахгүй байсан. Эрүүгийн хариуцлагыг зөвхөн ЭХ-д тусгасан байсан бөгөөд түүнд МУТСТ тухай хууль, ТТ хууль, УСҮАЖ зөрчлийг гэмт хэрэгт тооцох тухай байхгүй байсан. СБ-ад хүлээлгэх захиргааны арга хэмжээ нь гаргасан зөрчилтэй нь дүйцэхүйц, давтан үйлдэхээс сэргийлэхүйц биш байсан. Түүнчлэн Зөвлөмж 6-ын зөрчилд хүлээлгэх хариуцлага байхгүй байсан. СББМҮҮ-ээс зөвхөн нотариатчид МУТСТ тухай хуулийг мөрдөж буй нь тус хуулийн хамрах хүрээ явцуу байгааг илтгэнэ. Нотариат, ТББ-ад хүлээлгэх хариуцлага нь гаргасан зөрчилтэй нь дүйцэхүйц, давтан үйлдэхээс сэргийлэхүйц биш байсан.

121. ЗТХ-д 2017 оноос хойш оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр МУТСТ үүргээ биелүүлээгүй тохиолдолд хувь хүн болон хуулийн этгээдэд авах захиргааны арга хэмжээ нь хэрэгжиж эхэлсэн. ЗТХ-ын 5.10 болон 11.29 дүгээр зүйлд ТТХ болон МУТСТ тухай хуулийг зөрчсөн тохиолдолд ногдуулах зөрчлийг тусгасан. ЗТХ-ийн 11.29 дүгээр зүйлд МУТСТ хуульд заасан хэд хэдэн үүргийг зөрчихөд авах хэд хэдэн захиргааны арга хэмжээг тусгасан, жишээлбэл: ХТМ, баримт материалыг хадгалах, ЭӨ-ийн мэдээллийг цуглуулах, цахим шилжүүлэг, НҮБ-ын АЗ-өөс гаргасан хориг арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой үүргийг биелүүлээгүй байх, УТНБЭ, корреспондент банк, шинэ технологи, гуравдагч этгээдэд тулгуурлах, дотоод хяналт, өндөр эрсдэлтэй улс орон, СГТ мэдээлэх, хилийн боомт дээр бэлэн мөнгө мэдүүлэх болон улсын бүртгэлтэй холбоотой үүргүүд.

122. Гэмт этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй тохиолдол захиргааны шийтгэлийг ногдуулдаг. ЗТХ-ын 19.29 дүгээр зүйлд тусгасан захиргааны шийтгэлийн хэмжээ нь ТТХ-ийг

зөрчихөд хүлээлгэх ЗТХ-ын 5.10 дугаар зүйлд заасан шийтгэлээс бусад тохиолдолд гаргасан шийтгэлтэй нь дүйцэхүйц болон дахин үйлдэхээс сэргийлэхүйц байж чадаж байна. ЗТХ-ын 11.29-д заасан МУТСТ тухай хууль зөрчихөд хүлээлгэх шинэ захиргааны шийтгэл нь ойлгоход хэцүү байна.

123. ЗТХ-ийн 11.29.9, 11.29.20 болон 5.10 дугаар зүйлд заасан зөрчил нь Зөвлөмж 6-д нийцэж байна.

124. 2017 оны ХҮТ-нд дурдсан СББМҮҮ нартай холбоотой сул талыг траст болон компанийн үйлчилгээ үзүүлэгчдийг эс тооцвол МУТСТ тухай хуулийн 4.1 дүгээр зүйлийн дагуу арилгасан. ТББ-той холбоотой зөрчлийн хувьд 2017 оны ХҮТ-ийн гаргасан зөрчилд нь дүйцэхүйц болон дахин үйлдэхээс сэргийлэхүйц бус байна гэж үзсэн зүйлд өөрчлөлт оруулаагүй байна.

125. 2017 оны ХҮТ-гаас хойш МУТСТ тухай хууль зөрчсөн тохиолдолд ногдуулах шийтгэлийн тогтолцоо нь эрс сайжирсан байна. Гэсэн хэдий ч, ТТХ зөрчсөн ТББ-д ногдуулах захиргааны арга хэмжээ нь гаргасан зөрчилтэй нь дүйцэхүйц болон дахин үйлдэхээс сэргийлэхүйц биш байгаа бөгөөд Монгол Улсын нөхцөл байдал дахь терроризм болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэл дунд зэрэг байгаа гэдгийг харуулж байна.

126. Улсын тэтгэвэр болон хөрөнгө оруулалтын сан (Монгол Улс Зөвлөмж 1-ийн дагуу бага эрсдэлтэй гэж тогтоогоогүй.)-тай холбоотой сул тал илэрсэн хэдийн ч ХҮТ-тай холбоотойгоор үнэлгээний багаас Улсын тэтгэвэр болон хөрөнгө оруулалтын санг эрсдэл багатай гэж үзсэн.

110. **Монгол Улсын ЗӨВ.35-ын үнэлгээг Хэсэгчлэн биелүүлсэн (ХБ) хэвээр үлдээв**

3.2. ХҮТ-аас хойш өөрчлөлт орсон Зөвлөмжүүд

127. ХҮТ-гаас хойш Зөвлөмж 2, 5, 7, 8, 18, 21-д өөрчлөлтүүд орсон. Энэ хэсэгт Зөвлөмж 5 болон 18-тай холбоотойгоор тавигдсан шинэ шаардлагын талаар дурдах болно. Монгол Улс Зөвлөмж 2, 7, 8, 21-ийн шинэ шаардлагыг хэрэгжүүлж байгаа нь дахин үнэлүүлэх хүсэлтийн нэг хэсэг гэж үзэв.

Зөвлөмж 5 (Ихэнхийг биелүүлсэн (ИБ) үнэлгээтэй байсан)

128. 2016 оны 10 дугаар сард, Зөвлөмж 5 болон тайлбар хэсэгт “сан болон бусад хөрөнгө” гэсэнд нэмж тодруулга хийсэн бөгөөд, Зөвлөмж 5 болон 6 нь хөрөнгийн ижил цар хүрээнд хамаардаг болохыг тодруулахын тулд Зөвлөмж 5-ын тайлбар хэсэгт заасан “сан” гэснийг “сан эсвэл бусад хөрөнгө” гэж өөрчилсөн. Түүнчлэн “сан эсвэл бусад хөрөнгө”-ийн тодорхойлолтыг НҮБ-ын АЗ-өөс гаргасан тогтоолд (газрын тос болон бусад байгалын баялаг зэрэг эдийн засгийн эх үүсвэр) дурдагдсан терроризмыг дэмжих тодорхой хэрэгслийг илүү тодорхойлох зорилгоор өөрчилсөн. Дээрх өөрчлөлтийн дагуу 2017 оны 2 дугаар сард Шалгуур үзүүлэлт 5.2, 5.3, 5.4-т өөрчлөлт оруулсан.

129. Монгол Улс ХҮТ-аас хойш ТС гэмт хэргийн тодорхойлолтод өөрчлөлт оруулсан. Үүний үр дүнд тус тайлан нь Монгол Улс зөвхөн Зөвлөмж 5-д тавигдсан шинэ шаардлагыг бус Зөвлөмж 5-ыг бүхэлд хэрхэн хангаж байгааг авч үзэх юм.

130. Монгол Улс Зөвлөмж 5 дээр Ихэнхийг биелүүлсэн (ИБ) гэсэн үнэлгээтэй байсан. Террорист үйлдэл хийх зорилготойгоо аялал эсвэл сургалтын санхүүжүүлэх нь гэмт хэрэгт тооцогддоггүй байсан бөгөөд хуулийн этгээдэд тооцох ял шийтгэл нь гэмт хэргийг дахин үйлдэхээс сэргийлэхүйц биш байсантай холбоотой бага зэргийн дутагдал байсан.

131. ЭХ-ын 29.10 дугаар зүйлд шинээр тусгасан ТС гэмт хэргийн тодорхойлолт нь өмнөх гэмт хэргийн тодорхойлолттой ихээнхдээ тохирч байгаа ч үүнд хэд хэдэн ялгаа байна. “Бүтнээр эсвэл хэсэгчлэн” гэдэг үгийг хассан бөгөөд энэ нь гэмт хэрэг ТС-эд ашигласан хөрөнгийг хэсэгчлэн эсвэл бүхэлд нь хамарч байгаа эсэхийг тодорхойлох боломжгүй болсон. Хуулийн этгээдэд тооцох шийтгэлийн арга хэмжээ нь 45,600-152,000 ам.доллар болж нэмэгдсэн. Энэ хэмжээ нь Монгол Улсын нөхцөл байдлын хувьд гэмт хэргийг дахин үйлдэхээс илүү сэргийлж

байна гэж үзэж байна. Гэсэн хэдий ч хуулийн этгээдийг татан буулгах болон зөвшөөрлийг цуцлах арга хэмжээ авах боломжгүй хэвээрээ байна.

132. Монгол Улсын ТС гэмт хэрэг нь ЭХ-д зааснаар “хөрөнгө”-д хамааралтай бөгөөд шинэчлэгдсэн ФАТФ-ын стандартын дагуу “хөрөнгө эсвэл бусад хөрөнгө” гэх ойлголтыг хангалттай хэмжээнд хамарч байна гэж үзэж байна. Монгол Улс террорист үйлдэл үйлдэх зорилгоор болон үйлдэхээр төлөвлөх эсвэл үйлдэлд оролцохоор зорчиж буй хувь хүнийг эсвэл террорист үйл ажиллагаа явуулах сургалтад оролцох болон зохион байгуулах үйл ажиллагааг санхүүжүүлэх үйлдлийг гэмт хэрэгт тооцдоггүй хэвээр байна.

133. **Монгол Улсын ЗӨВ.5-ын үнэлгээг Ихэнхийг биелүүлсэн (ИБ) үнэлгээг хэвээр үлдээв.**

Зөвлөмж 18 (Ихэнхийг биелүүлсэн (ИБ) үнэлгээтэй байсан)

134. 2017 оны 11 дүгээр сард Зөвлөмж 18-ын тайлбар хэсэгт санхүүгийн нэгдэл дэх хэвийн бус эсвэл сэжигтэй гүйлгээтэй холбоотой шаардлагыг шинэчилсэн. 2018 оны 2 дугаар сард Зөвлөмж 18-ын тайлбар хэсгийн дагуу Зөвлөмж 18-ийг шинэчилсэн.

135. Монгол Улсад 18.2(b) хэсэгт дурдсан шинэ хэсгийг хамарсан тодорхой шаардлага байхгүй ч МУТСТ тухай хуулийн 14 дүгээр зүйл, УСҮАЖ-ын 11, 16.1, 16.2 дугаар зүйлийн дагуу Зөвлөмж 18-ын бусад бүх шалгуур үзүүлэлтүүдийг хангаж байна.

136. **Монгол Улсын ЗӨВ.18-ын үнэлгээг Ихэнхийг биелүүлсэн (ИБ) үнэлгээг хэвээр үлдээв.**

3.3. Биелүүлээгүй/Хэсэгчлэн биелүүлсэн үнэлгээ авсан бусад Зөвлөмжүүдийн хүрээнд авч хэрэгжүүлсэн ажлын товч танилцуулга.

137. Монгол Улс Биелүүлээгүй/Хэсэгчлэн биелүүлсэн үнэлгээ авсан бүх Зөвлөмжүүдийг ахиулахаар хүсэлт гаргасан

IV. ДҮГНЭЛТ

138. Монгол Улс ХҮТ-нд дурдсан техникийн хэрэгжилтийн дутагдлуудыг арилгахаар томоохон ахиц, дэвшил гаргасан бөгөөд нийт 16 Зөвлөмжийн үнэлгээг ахиулсан.

139. Монгол Улсын авсан арга хэмжээний дагуу Зөвлөмж 28-ийг ХБ үнэлгээтэй, Зөвлөмж 2, 6, 7, 17, 19, 22, 23, 24, 25, 26, 32, 33, 34-ийг Ихэнхийг биелүүлсэн (ИБ) үнэлгээтэй болгож ахиулсан, мөн Зөвлөмж 21, 29-ийг бүрэн биелүүлсэн (ББ) хэмээн дахин үнэлж байна. Зөвлөмж 1, 8, 14, 35 дээр үнэлгээ ахиулах хангалттай ажил хийгээгүй тул үнэлгээ дээшлүүлээгүй болно.

140. ХҮТ батлагдсанаас хойш өөрчлөлт оруулсан бусад Зөвлөмжүүдийн хувьд Зөвлөмж 5, 18-ийн үнэлгээг хэвээр нь хадгалав.

141. Ерөнхийдөө Монгол Улсын ХҮТ батлагдснаас хойш гарсан ахиц дэвшлийн тухайд ФАТФ-ын зөвлөмжийн техникийн хэрэгжилт дараах байдлаар гарсан байна.:

ЗӨВ. 1	ЗӨВ. 2	ЗӨВ. 3	ЗӨВ. 4	ЗӨВ. 5	ЗӨВ. 6	ЗӨВ. 7	ЗӨВ. 8	ЗӨВ. 9	ЗӨВ. 10
ХБ	ИБ	ИБ	ИБ	ИБ	ИБ	ИБ	ХБ	ИБ	ИБ
ЗӨВ. 11	ЗӨВ. 12	ЗӨВ. 13	ЗӨВ. 14	ЗӨВ. 15	ЗӨВ. 16	ЗӨВ. 17	ЗӨВ. 18	ЗӨВ. 19	ЗӨВ. 20
ББ	ИБ	ИБ	ХБ	ИБ	ИБ	ИБ	ИБ	ИБ	ИБ
ЗӨВ. 21	ЗӨВ. 22	ЗӨВ. 23	ЗӨВ. 24	ЗӨВ. 25	ЗӨВ. 26	ЗӨВ. 27	ЗӨВ. 28	ЗӨВ. 29	ЗӨВ. 30
ББ	ИБ	ИБ	ИБ	ИБ	ИБ	ИБ	ХБ	ББ	ББ
ЗӨВ. 31	ЗӨВ. 32	ЗӨВ. 33	ЗӨВ. 34	ЗӨВ. 35	ЗӨВ. 36	ЗӨВ. 37	ЗӨВ. 38	ЗӨВ. 39	ЗӨВ. 40
ББ	ИБ	ИБ	ИБ	ХБ	ББ	ББ	ИБ	ИБ	ИБ

142. АНДББ нь Монгол Улсын Дахин үнэлгээний тайланг 2019 оны 8-р сард зохион байгуулагдсан Жилийн уулзалтаар баталсан, энэ тайлангаар өргөтгөсөн эрчимтэй хяналтад (enhanced expedited follow-up) байсныг эрчимтэй хяналтад (enhanced follow-up)-д оруулсан. Монгол Улс МУТСТ арга хэмжээ хэрэгжүүлэхэд гаргасан ахиц дэвшлийн талаар АНДББ-д үргэлжлүүлэн тайлагнах болно.